

Увс аймаг дахь Төрийн аудитын газар



УВС АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2016 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН НЭГДСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын код: УВС-2017/1/СТА-ТЕЗ

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:	
Увс аймаг дахь Төрийн Аудитын газар	
Дарга, тэргүүлэх аудитор:	Нэг. Ерөнхий зүйл
Б.Авирмэд	Аудит хийсэн үндэслэл, хугацаа.....5
Аудитын менежер:	Аудитын зорилт, хамарсан хүрээ..... 5
Ж.Энхжаргал	Байгууллагын хууль, эрх зүйн орчин 5
Ахлах аудитор:	Байгууллагын зорилго үйл ажиллагаа 6
С.Алтанхундага	Хоёр. Санхүүгийн дотоод хяналт.....7
Ахлах шинжээч	Гурав. Шилэн дансны мэдээлэл..... 7
М.Батсуурь	Дөрөв. Материаллаг байдлыг тодорхойлох 7
2017 оны 4 дүгээр сар	Тав. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны санхүүгийн нэгдсэн тайлангийн талаар 7
Уг тайланг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын цахим хуудаснаас үзнэ үү:www.audit.mn	Зургаа. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар 7
Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70453721, 70454721 дугаарын утас, 70453317 дугаарын факсаар харилцана уу.	Долоо. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар 8
ХАЯГ:	Найм. Мөнгөн хөрөнгийн бүртгэл тайлагнал 8
Увс аймаг дахь Төрийн аудитын газар, ЗДТГ-ын байр, 3-р баг, Улаангом сум, Увс аймаг	8.1 Мөнгөн хөрөнгийн бүтцийн талаар 8
	Ес. Авлагын бүртгэл, тайлагнал 9
	9.1 Авлагын бүтэц, бүрэлдэхүүний талаар..... 9
	9.2 Авлагатай холбоотой илэрсэн зөрчлийн талаар 9
	Арван. Бараа материалын бүртгэл, тайлагнал 10
	10.1 Бараа материалын бүтэц, бүрэлдэхүүний талаар 10
	Арван нэг. Үндсэн хөрөнгийн талаар 11
	11.1 Үндсэн хөрөнгийн бүтэц, бүрэлдэхүүн, тайлагналын талаар..... 11
	11.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар үндсэн хөрөнгөтэй холбоотой гарсан зөрчлүүдийн талаар 12
	Арван хоёр. Өр төлбөрийн бүртгэл, тайлагнал 13
	12.1 Өр, төлбөрийн бүтцийн талаар..... 13
	12.2 Өр, төлбөртэй холбоотой зөрчил дутагдлын талаар 13
	Арван гурвал. Орлогын бүртгэл, тайлагнал 14
	13.1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны санхүүгийн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн талаар 14
	13.2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны санхүүгийн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн талаар 15
	Арван дөрөв. Зардлын бүртгэл, тайлагнал 15
	14.1. Зардлын бүтцийн талаар 15
	14.2. ОН-ийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар зардалтай холбоотой гарсан зөрчлүүдийн талаар 16
	Арван тав.Бараа үйлчилгээний зардалтай холбоотой гарсан зөрчлүүдийн талаар 16
	Арван зургаа. Хуримтлагдсан үр дүнгийн талаар 17
	Арван долоо. Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын бүртгэл тайлагнал 18
	17.1. Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын бүтцийн талаар 18
	Арван найм. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны санхүүгийн жилийн эцсийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн төсөл сангийн талаар 18
	18.1. Төсөл сангийн бүтцийн талаар 18
	18.2. Төсөл сангуудын мөнгөн хөрөнгийн талаар 19
	18.3. Төсөл сангуудын зөрчил дутагдлын талаар 19
	Арван ес. Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгдсэн тайланд хийсэн аудитын дүнгийн талаар 19
	Хорь. Тайлант оны аудитын зөвлөмж 20

ТОВЧИЛСОН ҮГ

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ОН	Орон нутаг
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
БОАЖГ	Байгаль орчин аялал жуулчлалын газар
БСШУЯ	Боловсрол соёл шинжлэх ухааны яам
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
УИХ	Улсын их хурал
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчийн аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч

Нэг. Ерөнхий зүйл

Аудит хийсэн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэгт заасан Увс аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн нэгдсэн тайланд аудит хийлээ.

Аудитын зорилт, хамарсан хүрээ, хугацаа

Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгдсэн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөхөд энэхүү аудитын зорилт чиглэгдлээ.

Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгдсэн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгдсэн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Увс аймаг дахь Төрийн аудитын газрын үүрэг юм.

Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгдсэн тайлангийн аудитыг 2017 оны 4 дүгээр сарын 03-наас 2017 оны 4 дүгээр сарын 20-ны хооронд хийхээр төлөвлөн Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Алтанхундага, ахлах шинжээч М.Батсуурь нар хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгдсэн тайлангаа 2017 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 5/415 тоот албан бичгээр Увс аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

Увс аймаг дахь Төрийн аудитын газар аудитыг 2017 оны 4 дүгээр сарын 03-наас 4 дүгээр сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 4 дүгээр сарын 20-нд Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчид гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин

Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч нь Монгол улсын “Төсвийн тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай”, “Төрийн албаны тухай”, “Хөдөлмөрийн тухай”, “Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэр, нэгж түүний удирдлагын тухай”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр

бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай” зэрэг хуулиуд болон бусад хууль эрхзүй, УИХ, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа

“Аймгийн төсвийн төлөвлөлт, бүрдүүлэлт, хуваарилалт, төсвийн ерөнхийлөн захирагчийн зарлага, санхүүжилтийг гүйцэтгэх, төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд эдийн засгийн шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг зохион байгуулах, хөрөнгө оруулалт, харьяа төсвийн байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа, төсөв, санхүүгийн орлого, зарлагын үйл ажиллагаанд байнгын хяналт тавих, төрийн болон орон нутгийн өмчийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлэх, эрх бүхий байгууллагын шийдвэрээр өмчийг ашиглах, зарцуулах, шилжүүлэх зэрэг үйл ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих зэрэг чиг үүргийг хэрэгжүүлэхэд оршино” гэж үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.17-д “аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга тухайн шатны орон нутгийн, энэ хуулийн 14.1.15, 14.1.16-д зааснаас бусад төсвийн ерөнхийлөн захирагч байна” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 14.1-д заасны дагуу Увс аймгийн Засаг дарга Төсвийн ерөнхийлөн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны санхүүгийн нэгдсэн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны санхүүгийн тайланг нэгтгэхэд баримталсан бодлого, аргачлал

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгдсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дугаар тушаалаар батлагдсан “Санхүүгийн нэгдсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу “е-тайлан” программаар бэлтгэн гаргажээ.

Тухайн нэгтгэлд хамрагдаж байгаа байгууллагуудын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэж байна.

Хоёр. Санхүүгийн дотоод хяналт

Бид санхүүгийн нэгдсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-д “Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитыг хэрэгжүүлэх” гэж заасныг баримтлан Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба төсвийн 97 байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж Төсвийн тухай хууль болон бусад хууль, тогтоомж түүнтэй холбогдон гарсан журам, шийдвэр, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалган илэрсэн зөрчил дутагдлыг засч, сайжруулах чиглэлээр зөвлөмж өгч ажилласан байна.

Гурав. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгдсэн тайланд нэгтгэгддэг төсвийн байгууллагууд төсвийн болон улс, орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, санхүүгийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хангаж **shilendans.gov.mn** вэб сайтад холбогдох мэдээллээ байршуулсан байна. Увс аймаг дахь Төрийн аудитын газар нь 2016 оны байдлаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд 2 удаа нийцлийн аудит хийж Төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн шууд захирагч нарт зөвлөмж өгч ажиллалаа. Аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу аймгийн Засаг дарга Санхүү хяналт, дотоод аудитын албанд үүрэг өгснөөр сар бүр тусгай маягт хөтлөн Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Дөрөв. Материаллаг байдлыг тодорхойлох

Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны жилийн эцсийн нэгдсэн санхүүгийн тайлангийн аудитын гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2016 оны үр дүнгийн нэгдсэн тайлангийн нийт зарлагын дүнг суурь болгон авч түүний 1 хувиар тооцон 755.6 сая төгрөгөөр тогтоов.

Тав. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2016 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Төсвийн ерөнхийлөн захирагчийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч нь 2016 онд улсын болон орон нутгийн төсвөөс урсгал зардалд 56973.3 сая төгрөг батлагдсанаас 56781.0 сая төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвийг 192.3 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Зургаа. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 1 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 1 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Үр дагавар: Аудитаар зөрчил илрээгүй болно.

Долоо. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар

Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгдсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн нэгдсэн тайланд нөлөөлөхүйц хэмжээний тайлагналын алдаа, хууль тогтоомжийн зөрчил гаргасан эсэхийг нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Найм. Мөнгөн хөрөнгийн бүртгэл, тайлагнал

8.1 Мөнгөн хөрөнгийн бүтцийн талаар

Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгдсэн тайлан дахь мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөд дараах зүйлсийг бүртгэж тайлагнасан байна. Үүнд:

- Төсвийн байгууллагуудын төрийн сан дахь банкны дансны үлдэгдэл,
- ОНӨҮГ-уудын арилжааны банкуудад байршдаг дансны үлдэгдэл,
- Төсөл сангийн төрийн сан дахь банкны дансны үлдэгдэл,
- Кассад байгаа бэлэн мөнгө

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгдсэн тайлангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 2015 оны эцэст 3357.7 сая, 2016 оны эцэст 2378.1 сая төгрөгөөр тайлагнажээ. Үүний 86.1 хувь буюу 2048.3 сая төгрөг төрийн сангийн болон төсөл сангийн харилцах дансанд байршсан үлдэгдэл байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн 2016 оны үлдэгдлийг бүтэц, байгууллагын төрлөөр харуулбал:

(сая төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Кассад байгаа бэлэн мөнгө	Банкинд байгаа бэлэн мөнгө	
				Арилжааны банк	Төрийн сангийн нэгдсэн данс
Кассад байгаа бэлэн мөнгө	4.9	2.9	2.9		
Банкинд байгаа бэлэн мөнгө	3352.8	2375.2	-	326.9	2048.3
Нийт мөнгөн хөрөнгийн дүн	3357.7	2378.1	2.9	326.9	2048.3
Үүнээс байгууллагын төрлөөр харуулбал:					
Төрийн сан	1429.4	843.5			843.5
Төсөвт байгууллагууд	193.4	197.9		0.00001	197.9
ОН-ын өмчит үйлдвэрийн газар	298.7	329.8	2.9	326.9	
Төсөл, сангууд	1435.9	1006.9			1006.9

Оны эхний үлдэгдэлтэй харьцуулбал төсөвт байгууллагуудын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 4.5 сая, орон нутгийн өмчит үйлдвэрийн газар 31.1 сая төгрөгөөр

өссөн, төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 585.9 сая, төсөл сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 429.0 сая төгрөгөөр тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Ес. Авлагын бүртгэл, тайлагнал

9.1 Авлагын бүтэц, бүрэлдэхүүний талаар

Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны жилийн эцсийн нэгдсэн санхүүгийн тайланд нийт авлагын эхний үлдэгдэл 6741.9 сая төгрөг байснаас тайлант онд 157.0 сая төгрөг буюу 2.3 хувиар буурч, оны эцэст 6584.9 сая төгрөг болсон байна.

Нийт авлагын үлдэгдлийг бүтцээр нь харуулбал:

Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү (сая төгрөгөөр)
Ажиллагсадтай холбогдсон авлага	0.9	0.8	(0.1)
Төлбөртэй үйлчилгээний авлага	1.4	1.3	(0.1)
Татаас, санхүүжилтийн авлага	2.8	3.3	0.5
Зээлийн хүүгийн авлага	33.9	60.2	26.3
Байгууллагаас авах авлага	1368.6	1129.0	(239.6)
Хувь хүмүүсээс авах авлага	4869.6	743.9	(4125.7)
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон	203.0	53.0	(150.0)
Дансны авлага /ТӨҮГ/	261.8	397.5	135.7
Татвар, НДШ-ийн авлага /НӨҮГ/	0.024	0.0	(0.024)
Хувь хүмүүст олгосон зээлийн	0.0	4168.6	4168.6
Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл	0.0	27.3	27.3
НИЙТ ДҮН	6741.9	6584.9	(157.0)

Дээрх хүснэгтээс үзэхэд Засгийн газрын байгууллага бусад шатны төсөвт олгосон зээлийн авлага 150.0 сая төгрөгөөр урьд оноос буурсан байна.

Авлагын үлдэгдлийг авч үзвэл улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр олгосон хугацаа хэтэрсэн /1994-2001 оныг хамарсан/ зээл 53.0 сая, сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн үлдэгдэл 4248.9 сая, мал хамгаалах сангаас олгосон зээлийн үлдэгдэл 465.1 сая төгрөг байна. Энэ нь нийт авлагын 72.4 хувийг эзэлж байна.

9.2 Авлагатай холбоотой илэрсэн зөрчлийн талаар:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд нэгтгэгддэг төсвийн байгууллагууд, төсөл сан, орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар авлагын данстай холбоотой нийт 32.0 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.2-д “Нягтлан бодох бүртгэлд авлагыг заавал бүртгэнэ”, 20.2.5-д “нягтлан бодогч нь дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах үүрэгтэй” зэрэг заалтууд, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн заавар”-ын Авлагын бүртгэлийн холбогдох заалтыг тус тус зөрчсөн байсныг аудитын явцад залруулсан байна. Тухайлбал:

- Сагил сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2016 оны жилийн эцсийн нэгдсэн санхүүгийн тайланд Сум хөгжүүлэх сангийн 250.0 мянган төгрөгийн авлага дутуу тайлагнасан,
- Тэс сумын Ахлах сургууль Ю.Цэндээгээс 66.0 мянга, Хүүхдийн цэцэрлэг “Тэс Цагаан толгой” ХХК-аас 1265.6 мянга, нийт 1331.6 мянган төгрөгийн авлагыг данс бүртгэлд тусгаагүй,
- БОАЖГазар нь Байгаль хамгаалах сангийн эх үүсвэрээр хийгдсэн ногоон байгууламжийн ажлын барьцааны 3.0 сая төгрөгийг авлага, өглөгөөр тайлагнаагүй,
- Мал хамгаалах сангийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Баруунтуруун сум 1418.0 мянган төгрөгийн авлагыг илүү, Сагил сум 510.0 мянга, Улаангом сум 500.0 мянга, Зүүнхангай сум 690,0 мянган төгрөгийн авлагыг дутуу илэрхийлсэн,
- ОНХС-ийн хөрөнгөөр Хяргас сум малжуулахын зээлд 21.0 сая төгрөг олгож санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй зардалд тайлагнасан,
- Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар нь “Олон бригад” ХХК-д халаалтын хөлсийг 562.0 мянган төгрөг илүү шилжүүлсэн боловч авлагаар тусгаагүй
- Аймгийн ЗДТГазар авлагыг 2660.7 мянган төгрөгөөр буруу илэрхийлсэн

Тэс сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгдсэн тайлангаар ИТХурал 52.3 мянга, ЗДТГ 1800.6 мянга, нийт 1852.9 мянган төгрөгийн авлага данс бүртгэлд тусгаагүй зөрчил илэрснийг арилгуулахаар албан шаардлага өгсөн байна.

Арав. Бараа материалын бүртгэл, тайлагнал

10.1 Бараа материалын бүтэц, бүрэлдэхүүний талаар

Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгдсэн тайланд нийт бараа материалын эхний үлдэгдэл 4322.8 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 4482.4 сая төгрөгөөр тайлагнаж, тайлант онд 159.6 сая төгрөгөөр өссөн байна.

Бараа материалын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	(сая.төгрөгөөр)	
			Зөрүү	Хувь
Тусгай зориулалтын материал	50.7	45.2	(5.5)	1,0
Эм боох материал	392.0	416.6	24.6	9.3
Бэлэн бүтээгдэхүүн	0,036	0,0	(0,036)	0.0
Бичиг хэргийн материал	176,9	207.0	30.1	4,6
Аж ахуйн материал	1474,2	1556.1	81.9	34,7
Сэлбэг хэрэгсэл	21,5	28.2	6.7	0,6
Түлш шатхуун, тослох материал	188,0	182.2	(5.8)	4,1
Барилга засварын материал	42,9	19.0	(23.9)	0.4
Хүнсний материал	256,7	300.0	43.3	6.7
Бусад хангамжийн материал	1674,9	1683.9	9.0	37.6
Мал амьтад	44,9	44,1	(0.8)	1.0
НИЙТ ДҮН	4322,8	4482.4	159.6	100.0

Бараа материалын өсөлтийг нэр төрлөөр нь авч үзвэл аж ахуйн материал 81.9 сая, хүнсний материал 43.3 сая, бичиг хэргийн материал 30.1 сая, эм боох материал 24.6 сая, бусад хангамжийн материал 9.0 сая, сэлбэг хэрэгсэл 6.7 сая төгрөгөөр өссөн бол барилга засварын материал 23.9 сая, шатах тослох материал 5.8 сая, тусгай зориулалтын материал 5.5 сая, мал амьтад 0.8 сая төгрөгөөр тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Нийт бараа материалын үлдэгдэлд хангамжийн материал 1683.9 сая төгрөг буюу 37.6 хувь, аж ахуйн материал 1556.1 сая төгрөг буюу 34.7 хувийг эзэлж байна.

Тайлант онд нэмэгдсэн бараа материалын хувьд төсвийн болон өөрийн хөрөнгөөр худалдаж авсан 6671.4 сая, хандив тусламжаар 94.5 сая, шилжүүлэн авсан 43.4 сая, бусад хэлбэрээр 111.0 сая, нийт 6920.3 сая төгрөгөөр өссөн байна.

Тайлант онд зарцуулсан бараа материалын хувьд зарцуулсан буюу худалдсан 6642.9 сая, шилжүүлсэн /зарим нь бүтцийн өөрчлөлтэй холбоотой/ 40.1 сая, бусад байдлаар зарцуулсан бараа материал 77.8 сая, нийт 6760.8 сая төгрөгөөр буурсан байна.

Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны санхүүгийн нэгдсэн тайланд хийсэн аудитаар бараа материалын бүртгэлтэй холбоотой нийт 21.4 сая төгрөгийн зөрчил илэрснийг тухайн шатны санхүүгийн тайланд залруулсан байна.

Дээрх үйлдэл нь УСНББОУС-1, УСНББОУС-12, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв байх зарчмыг баримтална”, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалаар батлагдсан журмын 1-р хавсралт “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар” Бараа материалын бүртгэлийн холбогдох заалтуудыг тус тус зөрчжээ. Үүнд

- ОНХСангийн эх үүсвэрээр Баруунтуруун сумын Засаг даргын тамгын газарт 14.4 сая, ахлах сургууль 5.0 сая, хүүхдийн цэцэрлэгт 2.0 сая төгрөгийн бараа материалыг бэлтгэж бүртгэлд тусгаагүй

Арван нэг. Үндсэн хөрөнгийн талаар

11.1 Үндсэн хөрөнгийн бүтэц, бүрэлдэхүүн, тайлагналын талаар

Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгдсэн тайлангийн үндсэн хөрөнгийн үлдэгдэл 2015 оны эцэст 189798.3 сая төгрөг байсан бол тайлант онд 5.3 хувь буюу 10008.8 сая төгрөгөөр нэмэгдэж 2016 оны эцэст 199807.1 сая төгрөгөөр тайлагнасан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайлан дахь хөрөнгийг төрөл тус бүрээр хүснэгтээр үзүүлбэл:

(сая.төг)

Ангилал	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү дүн
Барилга байгууламж	136488.0	148822.0	12334.0
Тээврийн хэрэгсэл	3847.6	4031.7	184.1
Машин тоног төхөөрөмж	13321.0	15203.4	1882.4
Тавилга эд хогшил	5421.7	5810.6	388.9
Дуусаагүй барилга	12215.5	3834.9	-8380.6
Зам, гүүрийн байгууламж	4007.8	7163.1	3155.3
Биет бус хөрөнгө	52.3	53.1	0.8
Програм хангамж	145.7	146.1	0.4
Ном	989.6	976.3	-13.3
Түүх соёл музейн дурсгалт	3807.8	3811.3	3.5
Бусад үндсэн хөрөнгө	9501.4	9954.7	453.3
Дүн	189798.3	199807.1	10008.8

Нийт үндсэн хөрөнгийн 74.5 хувийг барилга байгууламж, 7.6 хувийг автомашин, тоног төхөөрөмж, 17.9 хувийг бусад үндсэн хөрөнгө тус тус эзэлж байна.

Тайлант хугацаанд үндсэн хөрөнгө 21688.6 сая төгрөгөөр /үүний дотор худалдан авсан 889.2 сая, хандив тусламжаар 3791.1 сая, шилжүүлж авсан 7615.5 сая, бусад 9392.7 сая/ нэмэгдэж, 11679.8 сая төгрөгөөр /үүний дотор худалдсан 66.3 сая, акталсан 886.5 сая, шилжүүлсэн 10365.0, бүтцийн өөрчлөлтөөр 152.7 сая, бусад 209.2 сая хасагдаж, тайлант онд 9352.9 сая төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

11.2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгдсэн тайланд хийсэн аудитаар үндсэн хөрөнгөтэй холбоотой гарсан зөрчлүүдийн талаар:

Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны санхүүгийн нэгдсэн тайланд хийсэн аудитаар үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой нийт 171.1 сая төгрөгийн зөрчил илэрснийг тухайн шатны санхүүгийн тайланд залруулсан байна.

Дээрх үйлдэл нь УСНББОУС-1, УСНББОУС-17, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв байх зарчмыг баримтална”, 14.4.2-д “Нягтлан бодох бүртгэлд **бүх хөрөнгө**, хөрөнгө оруулалт, авлага заавал бүртгэнэ”, Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан журмын 6.1 дэх заалт, 2006 оны 388 тоот тушаалаар батлагдсан журмын 1-р хавсралт “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар” Үндсэн хөрөнгийн бүртгэлийн холбогдох заалтуудыг тус тус зөрчжээ. Үүнд

- ОНХС-ийн хөрөнгөөр Зүүнговь сумын Сургуулийн шалны засвар хийсэн 13.9 сая төгрөгийг бүртгэлд тусгаагүй,
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Зүүнхангай сумын Ахлах сургуульд хийсэн засварын ажлын 64.3 сая төгрөгийн хөрөнгийг дутуу тайлагнасан,
- Аймгийн ИТХ-ын 2015 оны 5-р сарын 15-ны А/65 тоот тогтоолоор актлахаар шийдвэрлэсэн Өлгий сумын ЗДТГазрын эзэмшилд байсан УАЗ-31512 маркын УВА 0366 дугаартай 14.1 сая төгрөгийн бүртгэлийн үнэтэй авто машиныг бүртгэлээс хасаагүй,
- ОНХС-ийн эх үүсвэрээр Өмнөговь сумын төвд баригдах замын зургийн үнэ 8.4 сая төгрөгийг зардалд тайлагнасан,
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Тэс сумын Ахлах сургуульд 2805 доллараар үнэлэгдэж ирсэн ухаалаг самбарыг тухайн үеийн Монгол банкнаас зарласан ханшаар нэг ам доллар 2482 төгрөг байхад 2000 төгрөгөөр үнэлж орлого авч 1352,0 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн,
- ОНХС-ийн эх үүсвэрээр Ховд сумын Ахлах сургуулийн халаалтын засварын ажлын зургийн үнэ 6.5 сая төгрөгийг зардалд тайлагнасан,
- БСШУЯамнаас Ховд сумын Ахлах сургуульд ирсэн автомашинд хийсэн доторлогооны үнэ 1.5 сая төгрөгийг урсгал зардалд тайлагнасан,
- Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь ИТХТэргүүлэгчдийн 2016 оны А/26 дугаар тогтоолоор 67.8 мянган төгрөгийн хөрөнгө актлах шийдвэр гарсныг хэрэгжүүлж бүртгэлээс хасаагүй,
- Байгаль орчин аялал жуулчлалын газар нь байгаль хамгаалах сангийн 61.0 сая төгрөгийн эх үүсвэрээр хийгдсэн ногоон байгууламжийн ажлыг зардлаар тайлагнасан

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгдсэн тайлангаар Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.2-д “Нягтлан бодох бүртгэлд **бүх хөрөнгө**, хөрөнгө оруулалт, авлага заавал бүртгэнэ”, Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан журмын 6.1 дэх заалтыг зөрчин 2 сум хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй зөрчлийг арилгуулахаар зөвлөмж өглөө. Үүнд:

- Баруунтуруун сумын Туруун голын модон гүүр, гүүр засварын ажил, гүний худгийг данс бүртгэлд тусгаагүй,
- ОНХСангийн хөрөнгөөр Сагил суманд хийсэн 19,9 сая төгрөгийн 0.4 кв шугамын ажлыг улсын комисс хүлээн авсан актыг үндэслэн холбогдох байгууллагын дансанд орлогод авч, бүртгэлд тусгаагүй,

Арван хоёр. Өр төлбөрийн бүртгэл, тайлагнал

12.1 Өр, төлбөрийн бүтцийн талаар

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгдсэн тайланд нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 4674.0 сая төгрөг байсан ба тайлант онд 996.9 сая төгрөгөөр буурч оны эцэст 3677.1 сая төгрөг болжээ. Үүнээс богино хугацаат өр төлбөрийн эхний үлдэгдэл 3731.4 сая байсан ба тайлант онд 1122.2 сая төгрөгөөр буурч оны эцэст 2609.2 сая төгрөг, урт хугацаат өр төлбөр 2.7 сая төгрөгөөр өсөж 945.3 сая төгрөг болжээ.

Нийт өр, төлбөрийн үлдэгдлийг байгууллагын төрлөөр харуулбал:



Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгдсэн тайланд тусгагдсан өр төлбөрөөс төсөвт байгууллага 11.2 хувийг, Төрийн өмчит үйлдвэрийн газар 71.4 хувийг, төсөл сан 16.1 хувийг, төрийн сан 1.3 хувийг эзэлж байна.

Урт хугацаат болон богино хугацаат өр төлбөрийн харьцаа



Тайлант хугацааны эцэст нийт өр төлбөрийн 73.4 хувийг богино хугацаат өр төлбөр, 26.6 хувийг урт хугацаат өр төлбөр тус тус эзэлж байна.

12.2 Өр, төлбөртэй холбоотой зөрчил дутагдлын талаар:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгдсэн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын хувьд өглөгийг буруу бүртгэсэн, өглөгийн

үлдэгдлийг харилцагч байгууллага, иргэнтэй тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй зэрэг нийт 68.0 сая төгрөгийн зөрчил илэрснийг санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Энэ нь УСНББОУС-1, УСНББОУС-15, УСНББОУС-19, Төсвийн тухай хуулийн 39.4.2-т “Өр, авлага үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв байх зарчмыг баримтална”, 14.4.3-д “бүх өр төлбөрийг бүртгэх”, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн заавар”-ын Өр төлбөрийн бүртгэлийн холбогдох заалтыг тус тус зөрчиж байна. Тухайлбал:

- Өмнөговь сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгдсэн тайланд өр төлбөрийн дансны тодруулгыг 16500.0 мянган төгрөгөөр өглөгийг илүү илэрхийлсэн,
- Тэс сумын Ахлах сургууль цалингийн өглөг гэж 2554.2 мянган төгрөгийг өглөг дансанд хасах, нэмэх тэмдэгтэйгээр дебет, кредит талд нь тайлагнасан,
- Ойрад хөгжимт драмын театр нь газрын төлбөр 217.0 мянган төгрөгийг өглөгөөр тайлагнаагүй,
- Улаангом сумын 1-р цэцэрлэг түлш халаалтын өглөгийг 603.6 мянган төгрөгөөр илүү тайлагнасан,
- Тэс сумын 2-р бага сургууль “Рашаант эхэн” ХХК-д өгөх өглөгийг 1980.0 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн,
- Аймгийн ЗДТГазар өглөгийг 44430.2 мянган төгрөгөөр илүү тайлагнасан,
- Аймгийн Орон нутгийн өмчийн газар нь санхүүгийн тайланд үндэслэх баримтгүйгээр 1800.0 мянган төгрөгийн тэтгэмжийн өрийг илүү, албан ажлаар ажилласан 0.2 мянган төгрөгийн томилолтын өрийг дутуу тусгасан,

Түүнчлэн Тэс сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгдсэн тайлангаар ИТХурал 153.0 мянга, ЗДТГазар 1853.5 мянга, ЭМТөв 5974.1 мянга, нийт 7980.6 мянган төгрөгийн өглөг бүртгэлд тусгаагүй зөрчил илэрхийлснийг арилгуулахаар албан шаардлага өгөв.

Арван гурав. Орлогын бүртгэл, тайлагнал

13.1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны санхүүгийн үр дүнгийн нэгдсэн тайлангийн талаар:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгдсэн тайлангийн үр дүнгийн тайлангаар үйл ажиллагааны орлогын нийт дүн 75664.5 сая төгрөг байгаа ба өмнөх онтой харьцуулахад 43030.2 сая төгрөгөөр буурсан байна.

			/сая төгрөг/
Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Зөрүү
Татварын орлого	5976.8	6645.9	669.1
Татварын бус орлого	43504.3	25252.2	-18252.1
Тусламж санхүүжилтийн орлого	69213.5	43766.4	-25447.1
Үйл ажиллагааны орлогын дүн	118694.7	75664.5	-43030.2

Дээрх хүснэгтээс харахад татварын орлого 669.1 сая төгрөгөөр өсөж, татварын бус орлого 18252.1 сая, тусламж санхүүжилтийн орлого 25447.1 сая төгрөгөөр буурсан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгдсэн үр дүнгийн тайланд хувь хүний орлогын албан татварын буцаан олголтын 936.0 сая төгрөгийг орлого бууруулан тайлагнасан байна.

Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны санхүүгийн нэгдсэн тайланд хийсэн аудитаар орлогын бүртгэлтэй холбоотой нийт 2.6 сая төгрөгийн зөрчил илэрснийг тухайн шатны санхүүгийн тайланд залруулсан байна.

Дээрх үйлдэл нь УСНББОУС-1, УСНББОУС-9, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв байх зарчмыг баримтална”, 14.4.5-д “Нягтлан бодох бүртгэлд **бүх орлого** заавал бүртгэнэ”, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалаар батлагдсан журмын 1-р хавсралт “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар” Орлогын бүртгэлийн холбогдох заалтуудыг тус тус зөрчжээ. Үүнд

- Байгаль орчин аялал жуулчлалын газар мөнгөн гүйлгээний тайланд 2.9 сая төгрөгийн орлого тайлагнаагүй,

Улаангом сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд нэгтгэгдсэн Увс эрдэм Ахлах сургууль нь үндсэн бус үйл ажиллагааны орлогыг төлөвлөөгүй байхад 9.5 сая төгрөгийн орлого төвлөрсөн байна. Цаашид уг орлогыг төсөвтөө төлөвлөж байхыг зөвлөмж болголоо.

13.2. ТЕЗ-ийн санхүүгийн үр дүнгийн нэгдсэн тайлангийн талаар:

Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгдсэн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно, 14.4.5, 14.4.6-д “Нягтлан бодох бүртгэлд **бүх орлого**, **бүх зардал** заавал бүртгэнэ” гэж заасныг зөрчснийг санхүүгийн тайланд залруулсан байна. Үүнд:

- Сагил сумын Дунд сургууль 2015 оны цалингийн урьдчилгааны 0.3 сая төгрөгийн авлагын бичилтийг буруу хийснийг залруулахдаа 2016 оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайланд үндэслэх анхан шатны баримтгүйгээр 0.3 сая төгрөгийн зардал тусгаж цалингийн зардлыг илүү илэрхийлсэн,
- Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газарт дээд байгууллагаас нь ирсэн санхүүжилт 5.6 сая төгрөгийг мөнгөн гүйлгээ болон үр дүнгийн тайланд тусгаагүй

Арван дөрөв. Зардлын бүртгэл, тайлагнал

14.1. Зардлын бүтцийн талаар

Тайлант оны Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгдсэн тайлангийн үр дүнгийн тайланд нийт зардал 73759.0 сая төгрөгийн зарцуулалттай тайлагнагдсан нь өмнөх оноос 22654.5 сая төгрөгөөр буурсан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгдсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг эдийн засгийн ангиллаар өмнөх болон тайлант оны зардлын эзлэх хувийг хүснэгт №1-ээр харуулав.

Нийт зардлыг бүтцээр нь харуулбал:

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН	ЭЗЛЭХ ХУВЬ
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	96413.5	73759.0	100
УРСГАЛ ЗАРДАЛ	91671.5	69782.4	94.6
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	53636.3	57461.2	77.9
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	30232.5	29730.3	40.3
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөхшигтгэл	3329.7	3270.1	4.4

Байр ашиглалттай холбоотой тогтмол. зардал	3731.6	4191.6	5.7
Хангамж, бараа материалын зардал	1337.5	1304.2	1.8
Нормативт зардал	3348.1	3481.9	4.7
Эд хогшил, урсгал засварын зардал	317.4	366.7	0.5
Томилолт, зочны зардал	287.6	238.9	0.3
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1011.1	2694.7	3.6
Бараа үйлчилгээний бусад зардал	10040.9	12182.8	16.5
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4741.9	3976.6	5.4
ТАТААС		23.0	0.03
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	38035.2	12298.2	16.7

Дээрх нийт зардлаас цалингийн зардал 44.7 хувь, бараа үйлчилгээний бусад зардал 16.5 хувь, урсгал шилжүүлэг 16.7 хувийг тус тус эзэлж байна.

14.2 Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгдсэн тайланд хийсэн аудитаар зардалтай холбоотой гарсан зөрчлүүдийн талаар:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны санхүүгийн тайлангийн нэгдсэн аудитаар зардлын данстай холбоотой нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандарт, журам, заавар мөрдөөгүй, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалаар батлагдсан журмыг зөрчсөн нийт 73.0 мянган төгрөгийн алдаа, зөрчлүүд илэрсэн байна.

- Аймгийн Орон нутгийн өмчийн газар нь цалингийн ашгийн 56.2 мянган төгрөгийг бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардалд бүртгэн гүйцэтгэлээр нь буруу ангилж тайлагнасан, цалингийн зардлаас 16.8 мянган төгрөгийн бичиг хэргийн зардалд зориулалт бусаар зарцуулсныг зөвлөмж болгожээ.

Арван тав. Бараа үйлчилгээний зардалтай холбоотой гарсан зөрчлүүдийн талаар

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгдсэн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар зориулалт бус зардал гаргасан нийт 22.7 сая төгрөгийн зөрчил илэрсэнд зөвлөмж өгсөн байна.

Энэхүү зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6.3.1-д “төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг бууруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр нь төлөвлөж, тайлагнах”, 6.4.1-д “төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4-д “Аж ахуйн нэгж байгууллага, нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв байх зарчмыг баримтлана”, 13.5-д “Анхан шатны баримтад түүний үйлдсэн зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж тамга тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажуулсан байна”, УИХ-ын 47 дугаар тогтоолоор “төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зардлыг хэмнэх, зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх”, Засгийн газрын 1995 оны 218 дугаар тогтоол, Сангийн сайдын 2014 оны “Төсвийн хэмнэлтийн горимд шилжих тухай” 122 дугаар тушаалын холбогдох заалтуудыг тус тус зөрчсөн байна. Тухайлбал:

- Наранбулаг сумын ЗДТГ, Ахлах сургууль төсвөөс нийт 811.8 мянган төгрөгийг гар утасны нэгжний зардал гаргасан,

- Наранбулаг сумын ЗДТГазар 1344.9 мянга, Ахлах сургууль 3222.8 мянга, нийт 4567.7 мянган төгрөгийг цалингийн зардлаас нэг удаагийн тэтгэмж олгож батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан,
- Сагил сумын ЗДТГ-ын ажилтнуудыг гадаадад аялахад 2.0 сая төгрөг зарцуулж төсвийн үр ашиггүй зарцуулсан,
- Сагил сумын Соёлын төв батлагдсан орон тоог хэтрүүлэн галч авч ажиллуулсан, хөгжмийн багшид эрхлэгчийн албан тушаалыг хавсруулан ажиллуулах Засаг даргын захирамж гарсан байхад эрхлэгчийн үндсэн цалинг хөгжмийн багшаас биш эрхлэгчийн албан тушаалын цалингаар цалинжуулж 0.7 сая төгрөгийн цалинг илүү тооцоолон олгосон,
- Аймгийн Номын сан нь принтерийн үнэ гэж 800.0 мянган төгрөг зарцуулснаас 350.0 мянган төгрөгөөр 2 вакум цонх авч зориулалт бус зардал гаргасан,
- Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь төрийн бус байгууллагаас зохион байгуулсан арга хэмжээнд 380.0 мянган төгрөгийг томилолтын зардлаас зарцуулсан,
- Ойрад хөгжимт жүжгийн театр нь томилоотоор ажилласан ажилтнуудын албан томилолтын хуудсанд ирсэн явсан өдрийг тэмдэглээгүй байхад 962.0 мянган төгрөг олгосон,
- Ойрад хөгжимт жүжгийн театр нь төгөлдөр хуур засварлах гэрээнд хэдэн хуур засах, хэдэн төгрөгийн хөлс олгох нь тодорхойгүй байхад ажлын хөлсөнд 1389.2 мянган төгрөг олгосон,
- Санхүүгийн хяналт, аудитын алба, Цогцолбор 2-р сургууль, Ахлах 3, 4-р сургууль нь төрийн бус байгууллагаас зохион байгуулсан арга хэмжээнд тус бүр 380.0 мянган төгрөгийг томилолтын зардлаас зарцуулсан
- Чандмань Эрдэм сургууль нь ур чадварын нэмэгдлийг 2 ажилтанд 35 хувиар буюу 10 хувиар илүү тооцон 0.6 сая төгрөгийг олгосон,
- Увс Эрдэм сургууль нь төрийн бус байгууллагаас зохион байгуулсан арга хэмжээнд 378.5 мянган төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлаас зарцуулсан,
- Байгаль орчин аялал жуулчлалын газар мөнгөн гүйлгээний тайланд 2.9 сая төгрөгийн зардал тайлагнаагүй,
- Өлгий сумын Засаг даргын тамгын газар “НИК” ХХК-д өгөх өглөгийн үлдэгдэл 1514.8 мянган төгрөгийг Онцгой байдлын газраас төлөгдснийг тээвэр шатахууны зардал бууруулж тайлагнасан

Тэс сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгдсэн тайлангаар Тэс сумын Эрүүл мэндийн төв нь Засгийн газрын 2012 оны 150 дугаар тогтоолын 1.4, 2001 оны 90 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 2 дах заалтыг тус тус зөрчин нийт 3455.0 мянган төгрөгийн нэмэгдэл цалин олгоогүй байсанд төлбөрийн акт тогтоолоо.

Түүнчлэн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 14.4.5, 14.4.6-д “ бүх орлого, зарлагыг нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ” гэж заасныг зөрчсөн байна. Үүнд:

- Тэс сумын ЗДТГазар 2.4 сая, ЭМТөв 3.9 сая, нийт 6.3 сая төгрөгийн анхан шатны баримтгүйгээр гүйлгээ хийсэн зөрчлийг арилгуулахаар албан шаардлага өгөв.
- Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар нь хүүхэд харах үйлчилгээний сургалтын төлбөр нэрээр 6.8 сая төгрөгийг анхан шатны баримтгүйгээр зарцуулсан зөрчлийг арилгуулахаар зөвлөмж өгөв.

Арван зургаа. Хуримтлагдсан үр дүнгийн талаар

Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгдсэн тайлангаар тайлант үеийн үр дүн 110.4 сая төгрөгөөр тайлагнагдсан бөгөөд хуримтлагдсан үр дүн 39451.2 сая төгрөг болсон байна.

Арван долоо. Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын бүртгэл, тайлагнал

17.1 ОНӨҮГ-ын бүтцийн талаар:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны жилийн санхүүгийн нэгдсэн тайланд Дулааны 2-р станц, Чандмань Увс, Шинэ Улаангом, Таван тэсийн илч, Эмийн эргэлтийн сан зэрэг орон нутгийн өмчит 5 аж ахуйн нэгж нэгтгэгдсэн байна.

ОНӨҮГ-ын 2015 оны орлого, зарлага, хуримтлагдсан үр дүн
/сая төгрөг/

ТӨҮГ-ын нэр	Орлого	Зарлага	Ашиг/алдагдал
Таван тэс илч	238.8	421.5	(182.7)
Дулаан 2 станц	1703.5	2949.1	(1245.6)
Чандмань Увс	316.6	317.0	(0.4)
Шинэ Улаангом	213.6	420.8	(207.2)
Эргэлтийн эмийн сан	683.0	683.4	(0.4)

Судалгаанаас харахад Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрууд алдагдалтай ажилласан байна. Алдагдалтай ажиллахад үндсэн хөрөнгийн элэгдлийн дүн тодорхой хэмжээнд нөлөөлж байна.

“Шинэ улаангом” ОНӨААТҮГ УСНББОУС-17 Хүлээн зөвшөөрөлт 19-т “ Үндсэн хөрөнгийг анх худалдан авах, эсвэл барьж байгуулахад гарсан зардал..... орно” гэж заасныг зөрчин барилга байгууламжийг барьж байгуулах зориулалт бүхий газрыг чөлөөлүүлэхэд гарсан 443.4 сая төгрөгийн зардлыг газрын сайжруулалт гэсэн дансанд бүртгэн буруу тайлагнасныг тухайн байгууллагын санхүүгийн тайлангаар залруулга хийлгэсэн байна.

Арван найм. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгдсэн тайланд нэгтгэгдсэн төсөл, сангийн талаар

18.1 Төсөл сангийн бүтцийн талаар

ТЕЗ-ын 2016 оны санхүүгийн нэгдсэн тайланд дараах сангууд нэгтгэгдсэн байна. Үүнд:

- Сум хөгжүүлэх сан
- Мал хамгаалах сан
- Байгаль хамгаалах сан
- Автозамын сан

Төрийн сан банк дахь зураг төсөв, барилгын барьцаа, орон нутгийн өмчийн сан, бусад сангийн данснуудын орлого зарлагын гүйлгээ нэгтгэгдсэн байна.

18.2 Төсөл, сангуудын мөнгөн хөрөнгийн талаар

Сангуудын 2016 оны жилийн эцсийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлийг хүснэгтээр харуулбал :

ДД	Сангийн нэр	/сая төгрөг/	
		Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл	
		Сан	Данс
1	Сум хөгжүүлэх сан	354.9	
2	Орон нутгийн өмчийн сан		71.9
3	Мал хамгаалах сан	115.4	
4	Барилгын барьцаа		383.1
5	Байгаль хамгаалах сан	59.7	
6	Бусад		6.9
7	Зураг төсөв		15.0
	ДҮН	530.0	476.9

18.3 Төсөл, сангуудын зөрчил дутагдлын талаар:

Зарим сумдын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгдсэн тайланд нэгтгэгдсэн сангуудын санхүүгийн тайлангийн аудитаар сумдын ОНХСангийн хөрөнгөөр бэлтгэсэн өвс тэжээлийг бусдад үнэгүй олгосон, шууд зардалд тусгасан, авлагаар бүртгээгүй зэрэг нийт 80.2 сая төгрөгийн зөрчил илэрснийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн байна.

Энэхүү зөрчил нь Төсвийн тухай хуулийн 25.10-д "Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно", Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан Орон нутгийн хөгжлийн сангийн зааврын 4.6-д "ОНХСангийн хөрөнгийг буцалтгүй тусламж, дэмжлэгэд зарцуулахгүй байх" гэж заасныг зөрчсөн байна.Тухайлбал:

- Давст сум ОНХС-аас бэлтгэсэн 9.8 сая төгрөгийн үнэ бүхий өвс, тэжээлийг малчдад олгон санхүүгийн тайланд авлага тусгаагүй,
- Малчин сум ОНХС-аас бэлтгэсэн 13.7 сая төгрөгийн үнэ бүхий өвс, тэжээлийг малчдад үнэгүй тараасан, урсгал зардалд 3.0 сая төгрөг зарцуулсан,
- Хяргас сум ОНХС-аас бэлтгэсэн 15.0 сая төгрөгийн үнэ бүхий өвс тэжээлийг малчдад олгон санхүүгийн тайланд авлага тусгаагүй
- Сагил сум ОНХСангийн хөрөнгөөр 20.0 сая төгрөгийн тэжээл бэлтгэснийг шууд зарлагдсан,
- Цагаанхайрхан сум ОНХС-аас бэлтгэсэн 18.7 сая төгрөгийн үнэ бүхий өвс тэжээлийг малчдад олгон санхүүгийн тайланд авлага тусгаагүй

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгдсэн тайлангаар Орон нутгийн хөгжлийн санг 13.8 сая, Сум хөгжүүлэх санг 25.5 сая, Байгаль хамгаалах санг 17.8 сая нийт 34.1 сая төгрөгөөр буруу тайлагнасныг залруулга хийлгэлээ.

Арван ес. Увс аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүнгийн талаар

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгдсэн тайланд нийт 240 байгууллага хамрагдахаас 151 байгууллага түүвэрт хамрагдаж 67 байгууллагад дүгнэлт өгч 22 байгууллагад итгэл үзүүлсэн байна. Үүнээс 66 байгууллагад зөрчилгүй, 1 байгууллага хязгаарлалттай дүгнэлт өгсөн байна. Увс аймаг дахь Төрийн аудитын газар 206 байгууллага, "Увс Финанс" хувийн аудитын компани 12 аудит хийж нэгтгүүлсэн байна.

Өмнөговь сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2016 оны жилийн эцсийн нэгдсэн санхүүгийн тайланд Хязгаарлалтай санал дүгнэлт өгсөн, Тэс, Өлгий сумууд санхүүгийн нэгдсэн тайлангаа хуулийн хугацаанд холбогдох санхүүгийн тайлан баримтуудаа гүйцэт ирүүлээгүй, аудитад саад учруулсан тул Төрийн аудитын тухай хуулийн 28.1 заалтын дагуу холбогдох албан тушаалтануудад хариуцлага тооцуулах албан шаардлагыг хүргүүлээ.

Увс аймаг дахь Төрийн аудитын газраас төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгдсэн тайлангийн аудитаар алдаа зөрчил илрээгүй ба төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэлд хамрагдсан байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 937.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 778.7 сая төгрөгийн алдааг залруулж, зөрчил дутагдлыг арилгах 27 зөвлөмж, 3.5 сая төгрөгийн төлбөрийн 1 акт тогтоож, 16.1 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах 3 албан шаардлага өгчээ.

Хорь. Тайлант оны аудитын зөвлөмж

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөөгүй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэлд хамрагдсан байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар тухайн байгууллагуудад нь зөвлөмжийг өгсөн тул санхүүгийн нэгдсэн тайланд зөвлөмж өгөх шаардлагагүй гэж үзлээ.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.АВИРМЭД

АУДИТЫН МЕНЕЖЕР:

Ж.ЭНХЖАРГАЛ

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР:

С.АЛТАНХУНДАГА

АХЛАХ ШИНЖЭЭЧ

М.БАТСУУРЬ